



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/450

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12/02 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 4.1.16, аймгийн Засаг даргын 2012 оны а/113 дугаар захирамжаар батлагдсан “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах аймгийн хөтөлбөр”-ийн 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын багийн үйл ажиллагааг дэмжих, иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай хүргэх боломжийг хангахад суурин компьютер, аймгийн Хөгжимт драмын театрт хурал, төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулахад шаардагдах эд материалын зардлыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх техник хэрэгсэл, эд материалын зардал болох 7,860,000 (долоон сая найман зуун жаран мянга) төгрөгийг аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100999

09 Аймгийн Засаг даргын 2020 оны
..... дугаар сарын-ны өдрийн дугаар
захирамжийн хавсралт

ТЕХНИК ХЭРЭГСЭЛ, ЭД МАТЕРИАЛЫН ЗАРДЛЫН ЗАДАРГАА

№	Техник хэрэгсэл, материал	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1.	Индэрийн ширээ	2 ш	1250.0	2500.0
2.	Суурин компьютер	1 ш	1580.0	1580.0
3.	Төрийн далбаа	8 ш	40.0	320.0
4.	Тугны суурь	8 ш	100.0	800.0
5.	Сандал	6 ш	260.0	1560.0
6.	Хурлын индэр	1 ш	1100.0	1100.0
Нийт дүн				7860.0

-oOo-